



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар **Байгаль орчны мэдээ**

2006 оны XI сарын 20

БӨХӨНГ ХУЛГАЙГААР ХӨНӨӨДӨГ БҮЛЭГ АНЧДЫГ ИЛРҮҮЛЭВ

Мэдээг бэлтгэсэн: Хууль бус агнууртай тэмцэх Ирвэс-3 багийн ахлагч, байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч **Ша.Гантулга**
ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны бүсийн салбарын
Байгаль хамгааллын ажилтан **О.Мөнхтогтох**

2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Ховд аймгийн Чандмань сумын иргэн Гончиг овогтой Алтангэрэлийн ЗИЛ-130 маркийн УБМ 92-39 дугаартай машины запас дугуйнд монгол бөхөнгийн 54 хос буюу 108 ширхэг эвэр хууль бусаар нууж авч явсныг илэрүүллээ. Эдгээр эврийг БНХАУ-руу хил давуулан худалдаалахаар авч явсан байна.



Эд мөрийн баримт болох 54 бөхөнгийн 108 ширхэг эвэр.

Хэргийг шалгах явцад Ховд аймгийн Чандмань сумын иргэн Балт овогтой Баянбаатар, Дашдорж овогтой Цогоо, Даваа овогтой Мөнхчулуун нарын 13 хүн бүлэглэн үйлдсэн болохыг тогтоож, эрүүгийн хэрэг үүсгэн Ховд аймгийн Цагдаагийн газрын хэрэг бүртгэх алба, хууль бус агнууртай тэмцэх Ирвэс-3 баг хамтран шалгаж байна.

Одоогоор хэргийн холбогдогч нарыг Ховд аймагт саатуулж байна. ТОЗ-8 маркийн дөрвөн буу хураан авсан болно.

Монгол улсын Засгийн газрын 2005 оны 248-р тогтоолд заасан экологи, эдийн засгийн үнэлгээгээр тооцвол байгаль орчинд 216 сая төгрөгөөр үнэлэгдэх хохирол учруулжээ.



Энэ хэрэгт холбогдох хүмүүсийн дотор өмнө нь бөхөнгийн эврийг хилээр гаргаж, эрүүгийн хариуцлага хүлээж байсан хүмүүс байна. Үүнээс үзвэл уг амьтныг хууль бусаар агнаж, эврийг нь хил давуулан худалддаг гаршсан этгээдүүд баригдсан болно.

Уг хэрэг хуулийн дагуу хэрхэн шийдэгдсэн талаарх мэдээг дараагийн дугаарт мэдээлнэ.